
Байгууллагын бүтэц ба менежерүүдийн үүрэг



ДЭМБ: ЧУТ 4.3

Агуулга

- Байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх мэдэл болоод үүрэг
- Байгууллагын гүйцэтгэх үйл ажиллагааны төрөл, үүргүүдийг нарийн тодорхойлохын ач холбогдол
- Чанарын менежерийн гүйцэтгэх үүрэг

Байгууллагатай холбоотой нэр томъёо

Байгууллага

- Үүрэг, эрх мэдэл, харилцааг нарийн тогтоож, зохион байгуулсан бүлэг хүмүүс болон тасаг, нэгжүүдийн цогц

Байгууллагын бүтэц

- Хүмүүсийн үүрэг болон тэдний хоорондох харилцааг нь нарийн тогтоосон зохион байгуулалт

Эрх мэдэл ба үүрэг (1)

- Байгууллагын бүх ажиллагсад өөрсдийн харъяалал, захирах, захирагдах дараалал, эрх мэдэл, үүргээ тодорхой мэддэг байх шаардлагатай.
- Ажиллагсадад тодорхой эрх мэдэл олгохгүйгээр зөвхөн үүрэг хариуцуулж болохгүй.
- Байгууллагын үйл ажиллагааны зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц зохион байгуулалтын зургийг гаргаж, мэдээлэх ёстой.

Эрх мэдэл ба үүрэг (2)

- Байгууллагын тасаг нэгжүүд тус тусдаа салангид бус, нэгмэл байдлаар ажиллах нөхцлийг хангасан бүтэц, зохион байгуулалттай байх ёстой.
- Байгууллагын бүтэц, зохион байгуулалтын зургийг гаргаж баримтжуулах шаардлагатай.
- Чанарын менежер нь тодорхой үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүсээс ангид, биеэ даан ажиллах ёстой.

Бүтэц, зохион байгуулалтын зургийн жишээ (1)



Бүтэц, зохион байгуулалтын зургийн жишээ (2)



Ажиллагсад ба байгууллага (1)

- Байгууллагынхаа үүргийг ажиллагсад тодорхой мэддэг байх ёстой.
 - Тус байгууллага ямар ажил гүйцэтгэдэг вэ?
 - Тус байгууллагын үйлчлүүлэгчид нь хэн бэ?

Ажиллагсад ба байгууллага (2)

- Байгууллагын бүтэц зохион байгуулалт, гол зорилго зорилт тодорхой байвал, бүх ажиллагсад нь гүйцэтгэх үүргээ бүрэн ойлгож чадна.
 - Хэнд захирагдаж, ажлаа тайлагнах вэ?
 - Ямар ажил гүйцэтгэх вэ?
 - Яагаад энэ ажлыг хийдэг вэ?
 - Ажил, үүргээ буруу гүйцэтгэснээс ямар үр дагавар үүсэх вэ?
 - Тасаг нэгжүүд хэрхэн харилцан уялдаж, ажиллах вэ?

Чанарын менежер

- Удирдлагаа төлөөлнө.
- Байгууллагын даргатай шууд харилцаж, мэдээлнэ.
- Байгууллагын үйлдвэрлэл буюу үзүүлдэг үйлчилгээнд оролцохгүй, хянах үүрэгтэй.
- Чанарын тогтолцоог нэвтрүүлж, тогтмолжуулах үүрэг хүлээхийн зэрэгцээ тодорхой эрх мэдэл эдлэнэ.

Чанарын менежерийн үүрэг

- Чанарын тогтолцоог нэвтрүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, уг тогтолцоог хэвшүүлэх
- Цусны албаны бүх ажиллагсдыг чанарын хөтөлбөрт хамруулах
- Байгууллагад чанарын соёлыг хөгжүүлэх
- Ажиллагсдад зориулж чанарын тогтолцооны талаар сургалт зохион байгуулах
- Байгууллагын тасаг нэгж бүрд чанарын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг дэмжих, зөвлөн туслах

Гол ойлголт (1)

- Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг нарийн тогтоох нь үйл ажиллагааг саадгүй хэрэгжүүлэхэд маш чухал ач холбогдолтой.
- Байгууллага бүхэн бүтцээ албан ёсоор батлуулсан байх шаардлагатай.
- Байгууллагын дотор эдлэх эрх мэдэл, гүйцэтгэх үүргийг тодорхойлсон байх ёстой.
- Байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлэхийн тулд бүтэц, зохион байгуулалтыг улам боловсронгуй болгох ёстой.

Гол ойлголт (2)

- Чанарын тогтолцоог нэвтрүүлэх хэвшүүлэх үүргийг чанарын менежер хүлээдэг.
- Чанарын менежер аль ч тасаг нэгжид харьяагдахгүй биеэ даан ажиллах ёстой.
- Чанарын менежер байгууллагынхаа удирдлагатай шууд харилцаж, мэдээлдэг байх ёстой.

Энэ хичээлийг үзсэний үр дүн

Одоо та бүхэн дараах чадварыг эзэмшлээ. Үүнд:

- Чанарын тогтолцооны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь, яагаад байгууллагын бүтэц зохион байгуулалт байдгийг тайлбарлах,
- Ямар нэг үйлдвэрийн газрын бүтэц зохион байгуулалтын энгийн зургийг гаргах
- Чанарын менежерийн гүйцэтгэх үүргийг нэрлэх